



# ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/262

Эрдэнэт

┌ Арга хэмжээ зохион байгуулах тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоол, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 1.1.9.2, 1.1.9.4, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 1.1.9.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/166 дугаар тушаал, "Элэгний вирусгүй Эрдэнэт хот" аяныг зохион байгуулах ажлын хүрээнд зорилтот бүлгүүдэд элэгний "В", "С" вирусийн шалтгаант өвчлөлийн талаарх мэдээлэл өгөх, өвчлөлийг эрт илрүүлэх, эмчлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталж "Эрдэнэтийн эрүүл иргэн" ТББ-тай 2017 оны 05 дугаар сарын 09 -ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хамтран ажиллах гэрээ байгуулан төрийн зарим үйлчилгээг гүйцэтгүүлсүгэй.


2.Шаардагдах зардал 14500000/ Арван дөрвөн сая таван зуун мянган / төгрөгийг 2017 онд зарцуулах төсөл хөтөлбөрийн Засгийн газрын "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгүүдэд элэгний хорт хавдар, В,С вирусийн халдварыг эрт илрүүлж, өвчлөлийг бууруулах, эмчлэх ажлыг зохион байгуулах зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н. Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсэг /н.Түвшинжаргал/, Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/, Эрүүл мэндийн газар /н.Баттүвшин/-т тус тус үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны  
05 дугаар сарын 22-ний өдрийн  
4/262 дугаар захирамжийн хоёрдугаар  
хавсралт

**“В”, “С” ВИРУСИЙН ӨВЧЛӨЛИЙГ ЭРТ ИЛРҮҮЛЭХ, ЭМЧЛЭХ, ӨВЧЛӨЛӨӨС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД  
ШААРДАГДАХ САНХҮҮЖИЛТ**

№	НЭР	Т/Ш	НЭГЖИЙН ҮНЭ	НИЙТ ҮНЭ
<b>Нэг. 05.20-нд өрхийн эмнэлгээр хийгдэх үйл ажиллагааны зардал</b>				
1	<b>Өрхийн эмнэлгийн багц</b>	<b>9</b>	<b>829000</b>	<b>7561000</b>
1.1	Тест (В, С вирус)	150	2800	420000
1.2	Вакум теннер	150	500	75000
1.3	1гр шприц	150	100	15000
1.4	Тарианы хөвөн	20	500	10000
1.5	Аюулгүйн хайрцаг	5	1800	9000
1.6	Урамшуулал	1	200000	200000
1.7	Сургалт	1	100000	100000
2	<b>Тээврийн зардал</b>	<b>2</b>	<b>50000</b>	<b>100000</b>
	<b>Нийт</b>			<b>7561000</b>
<b>Хоёр. Сурталчилгаа, бусад</b>				
1	В вирус илрүүлэх тест	1000	1350	1350000
2	С вирус илрүүлэх тес	1000	1450	1450000
3	Вакум теннер	1000	500	500000
4	1 гр шприц	1000	100	100000
5	Гарын авлага, брошюр	8000	300	2400000
6	ТВ хичээл, нэвтрүүлэг, шторк	1удаа	150000	150000
7	Сургалт (Эмч нарыг сургах, иргэдэд зориулсан)	2удаа	200000	400000
9	Зохион байгуулалтын бусад зардал	1	589000	589000
	<b>Нийт</b>			<b>6939000</b>
	<b>Нийт</b>			<b>14500000</b>